



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 1/50

Хэрлэн сум

Сахилга хариуцлагыг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн албан хаагчид эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах тохиолдолд батлагдсан төсөвт багтаан зардлын 80 хувийг урьдчилан олгож ажиллахыг төрийн байгууллагын төсвийн шууд захирач, орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг бол госугай.

2. Албан томилолтоор ажиллаж ирснээс хойш ажлын 3 өдрийн дотор багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг илтгэх хуудсаар эрх бүхий албан тушаалтанд танилцуулан баталгаажуулж холбогдох баримтыг бүрдүүлсний үндсэн дээр зардлын тооцоог бүрэн хийж дуусгахыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хянаат тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг бол госугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

